



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№62 /276/

2022.03.30

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХЫН НЭГДМЭЛ ХЯНАЛТ



Батлан хамгаалах салбарын төсөв, төрийн өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалал, нягтлан бодох бүртгэл хөнгөлөлт, түүнд тавигдах дотоод хяналтыг сайжруулах зорилго бүхий сургалтыг БХЯ-ны хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас зохион байгуулав. Тус сургалтад танхимаар Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, Төрлийн цэргийн командлал, Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч нараас гадна цахимаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллага, БХЯ-ны харьяа байгууллагын захирагч, дарга, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогчид оролцож байна.

Сургалтын эхэнд Батлан

хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар хэлсэн үгэндээ “Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн, мэргэшсэн, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд, төрийн өмч хөрөнгийг үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжих, салбарын хэмжээнд санхүү, төсвийн хариуцлагатай удирдлагыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалахын сайд онцгойлон анхаарч байна. Энэ ч үүднээс сүүлийн 2 жилийн хугацаанд Батлан хамгаалахын хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналт шалгалтын нэгжүүд, нэгтгэл, анги байгууллагын ажлын хэсгийн чиг үүрэг, ажлын уялдаа холбоог зохицуулах дүрэм журмууд батлагдан, хяналт шалгалтын бүтцийн нэгжүүд нэгдмэл бодлого,



төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм. Мөн батлан хамгаалах салбарын нэгдмэл хяналтын гол зорилго нь Батлан хамгаалахын сайдын хуулиар хүлээсэн үүргүүдийг нэгдсэн бодлогоор хангаж Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих ажилд дэмжлэг үзүүлж байна. Тиймээс өнөөдрийн сургалтаар байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахын ач холбогдлыг ойлгуулах, албан тушаалтнуудын төрийн өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалттай холбоотой үүрэг, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, дотоод аудит санхүүгийн хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил дутагдлыг цаашид засаж арилгахад үр дүнгээ өгнө гэдэгт итгэж байна” гэв.

Тус сургалтын хүрээнд Батлан хамгаалах салбарын 2021 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын

дүнг танилцуулахыг зэрэгцээ дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил дутагдал цаашид анхаарах асуудал, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шууд захирагч, ерөнхий нягтлан бодогч, материал техникийн алба хариуцсан ажилтан, алба хаагчдын хуулиар хүлээсэн эрх үүргийн талаарх хичээлүүдийг шологдох албан тушаалтнууд орсон юм. Мөн дотоод хяналт шалгалтын удирдлага, зохион байгуулалт, төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалт, тооллогын байдалд хяналт тавих, батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүнийг албаны нэгдсэн мэдээлэл, мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангах мэдээллийн цахим хуудсыг танилцууллаа.



“ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ХУУЛЬ ДҮРМИЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ”



“Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 101 жилийн ойд зориулж ЗХЖШ-ын Материал техникийн газрын Техникийн хангалтын хэлтэс, Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба хамтран “Замын хөдөлгөөний хууль дүрмийг хэн сайн мэдэх вэ” тэмцээнийг зохион байгуулж байна.

Зэвсэгт хүчний нэгтгэл анги байгууллагын жолооч, техникийн офицер, ахлагч ажилтан алба хаагчдын замын хөдөлгөөний хууль дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх, зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой тус тэмцээнд Зэвсэгт хүчний 14 ангийн 90 гаруй офицер, ахлагч, ажилтан алба хаагчид хөгжөөн дэмжигчдийн хамт оролцож байгаа юм.

Нэг баг зургаан хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэд мэндчилгээ, зөрчлийн хуулиар бэлтгэсэн асуулт хариулт, замын хөдөлгөөний дүрмийн тест, гэрийн даалгавар гэсэн 4 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ шалгаруулаа.

Тэмцээний шүүгчдээр ЗХЖШ-ын МТГ-ын Техникийн хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Б.Энхболд, Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч А.Нямдорж, Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч ахлах дэслэгч Э.Өнөболд нар ажиллаж байгаа юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,272,398 /69.8%/	2,174,509 /66.8%/	1,032,361 31,7%
		114,632 /3,5%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8435 +112	3	8311

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 485,592,258

Эдгэрсэн
Нийт: 415,873,006

Нас барсан
Нийт: 6,157,201

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
Өдөр	Шөнө
☀️ 0	🌙 -18
ӨМНӨД СУДАН	
Өдөр	Шөнө
☀️ 41	🌙 27

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,000.00	3,010.0
EUR 🇪🇺	3,400.0	3,450.0
CNY 🇨🇳	492.00	497.00
RUB 🇷🇺	34.50	36.50
JPY 🇯🇵	26.50	27.80
KRW 🇰🇷	2.57	2.60

ЗУРХАЙ

2022.03.30 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 28/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:
Хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.35-19.18
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Нэр өнгө
Суудал: Мод

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лусыг тахиx, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



ДЭЛХИЙН ЭМЧ НАРЫН ӨДРИЙН МЭНДИЙГ ХҮРГЭЭ

Цахим шууданд

"ЦЭРГИЙН БОДОЛ"-ТОЙ ДАЙЧДЫН НЭГ ӨДӨР



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын урилгаар "Хурд" хамтлагийнхан Өвөрхангай аймагт ажиллалаа. Энэ үеэр тус хамтлагийнхан Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдад "Цэргийн алба, үүрдийн нөхөрлөл", "Эх орны хөвгүүдээр бахдагч" өдөрлөгийг зохион байгуулж, цэрэг-эх

оронч үзэл, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлсэн чөлөөт ярилцлагыг өрнүүлээ.

Үүний зэрэгцээ авьяаслаг хугацаат цэргийн алба хаагчдын төлөөлөл "Хурд"-ын дуунуудаар мэндчилгээ дэвшүүлэхэд хариу талархал илэрхийлэн, бүрэн хэмжээний тоглолтыг дайчдад өргөн барьсан юм. Энэ талаар тус хамтлагийн гитарчин Д.Отгонбаяр

"Цэргийн алба гэдэг үнэхээр сайхан. Бидний өнөөдрийн амжилт бол Зэвсэгт хүчинтэй салшгүй холбоотой. Эр цэргийн албаар дамжсан эр хүн хэзээ ч алддаггүй юм" хэмээгээд дайчдын цаашдын албанд өндөр амжилт хүслээ. Цэрэг-эх оронч үзлийг түгээсэн энэхүү арга хэмжээнд аймгийн удирдлагууд мөн оролцсон юм.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАН ЯВУУЛАА



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Зэвсэгт хүчний Байр зүйн албаны 90 жил, Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн түүхт 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний хүрээнд ангийн үндсэн салбаруудын гүйцэтгэх үүргийн онцлогтой уялдуулан "Гурван цагийн хэлхээс" сэдэвт цуврал уулзалт,

хэлэлцүүлгийг энэ сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Уг хэлэлцүүлгээр "Орон зайн тандалт, мэдээллийн өнөөгийн байдал, туршлага, сургаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, хэтийн төлөв"-ийн талаар харилцан мэдээлэл солилцсон юм.

Уулзалт, хэлэлцүүлэгт ЗХЖШ-ийн АУГ-ын Орон зайн тандалт, судалгааны

мэргэжилтэн дэд хурандаа Б.Энхбаясгалан, БСТГ-ын мэргэжилтэн дэд хурандаа Д.Төмөрбат, Тусгай хүчний цэргийн командлалын тагнуулын офицер хошууч Э.Мөнхтөр болон ангийн удирдлага, орон зайн тандалт, мэдээллийн тасгийн бүрэлдэхүүн оролцлоо.

Хошууч Л.ДАВААЦЭРЭН

БОДИБИЛДИНГИЙН СПОРТЫН МАСТЕРТАЙ БОЛОВ



Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Зэвсэгт хүчний 350 дугаар анги бодибилдингийн тамирчинтай боллоо. Тодруулбал, ангийн ахлагч М. Аюурзэд нь хэдхэн хонгийн өмнө зохион байгуулагдсан "Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн-2022"-ийн 75кг-нд тэргүүн байрт шалгарч спортын мастер болсон юм.

Тэсвэр тэвчээр, хөлс хөдөлмөр, хөрөнгө мөнгө цаг хугацаа шаарддаг энэхүү спортод түүний гаргасан амжилтууд багагүй аж. Тухайлбал, тэрээр анх 2016 оноос эхэлж хичээллэж, тэмцээн уралдаанд оролцож эхэлсэн ба 2017 онд "George cup" тэмцээний 70кг-ийн жинд дөрөвдүгээр байр, "Монголын мистер" тэмцээн 65кг-ийн жинд

гуравдугаар байр, 2018 онд "Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн"-ийн 65кг-ийн жинд гуравдугаар байр, "Монголын мистер" тэмцээний 65кг-ийн жинд дэд байр, 52 дахь удаагийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний 75кг-ийн жинд дөрөвдүгээр байр, 2019 онд "Зүүн азийн аварга шалгаруулах тэмцээн"-ийн 70кг-ийн жинд гуравдугаар байр, "Монголын мистер"-тэмцээний 70кг-ийн жинд тавдугаар байр, "Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн"-ийн 70кг-ийн жинд зургаадугаар байр, 2019 онд "Зүүн азийн аварга шалгаруулах тэмцээн"-ийн 70кг-ийн жинд дэд байруудад шалгарч байсан аж.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАКТИКИЙН ДАДЛАГА, СУРГУУЛИЙГ ЯВУУЛАВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Нэгтгэлийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу нэгтгэлийн галын алба, Төв аймгийн онцгой байдлын газартай хамтран гал түймэр унтраах тактикийн дадлага, сургуулийг амжилттай явууллаа. Сургалтын хүрээнд тусгай үүргийн бүлгүүд болон нэгтгэлийн нийт бие бүрэлдэхүүнтэй гамшгийн сургалтуудыг зохион байгуулж төгсгөлд нь аймгийн гал түймэр унтраах 24 дүгээр ангитай

хамтарсан тактикийн дадлага сургуулийг зохион байгуулав. Тус дадлага, сургуульд нэгтгэлийн гал унтраах алба 2 нэгж техниктэй, эмнэлгийн алба 1 нэгж техниктэй, мотобуудлагын батальоны орон тооны бус галын салааны томилгоот хугацаат цэргийн алба хаагчид, аймгийн гал түймэр унтраах 24 дүгээр анги 20 цэргийн алба хаагч, 2 нэгж техниктэйгээр оролцсон юм. Энэхүү дадлага, сургууль нь сүүлийн 20 гаруй жил Зэвсэгт хүчний хэмжээнд явагдаагүй гэдгээрээ онцлог байлаа.



30 КМ-ИЙН ЯВГАН МАРШААР...



Нэгтгэлийн ахлагчийн зөвлөлөөс 2021-2022 оны сургуулийн жилд ахлагчийн албыг хөгжүүлэх, ахлагч нарын сургалт бэлтгэл, сэтгэл зүйн бэлтгэл, бие бялдар, цэргийн алба, сахилга зохион байгуулалт, нийгмийн асуудлыг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор олон арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Энэ арга хэмжээний хүрээнд ахлагчийн бие бүрэлдэхүүнтэй тактик тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг "Бие бүрэлдэхүүний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх, салаадууд бие даан үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх" зорилготойгоор зохион байгуулан явууллаа.

Явган маршийг 1 маршрутаар боловсруулах асуудлын хүрээнд хичээлийн 4 цэгээр төлөвлөн маршийн явцад тактикийн бэлтгэлийн 5, 6, 8, 9, 10, 11 дүгээр нормативыг боловсруулах, түр амралтын районд энхийг сахиулах чиглэлээр машин нэгжих, хүн нэгжих, түр шалган

зохион байгуулах сургалт зохион байгуулах, цугларах районд холбоо зохион байгуулах, Р-107 радио станцийг ажилд бэлтгэх, цацраг химийн хордолт хэмжих тагнуулын багаж



хэрэгслийг ажилд бэлтгэх, ВПХР химийн тагнуулын багаж, ДП-5В цацрагийн тагнуулын багаж, амьд гарах арга ухаан сэдвээр өөрийн гарын доорх материалаа хэрхэн яаж ашиглах талаар бүлэг тус бүрт сургалт зохион байгуулсан юм.

Цаашид даргалах албан тушаалын ахлагч нарын хүнтэй ажиллах, хичээл сургууль удирдах үр

чадвар арга барилд сурган дадлажлуулах, ахлагч нарын бие даан үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, дадлагуудыг явуулаа. Мөн ахлагчийн бүрэлдэхүүний амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, хамт олонч нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор спортын тэмцээнүүдийг гар бөмбөг, шатар, даам, теннис, билльярд гэсэн төрлүүдээр зохион байгуулж явууллаа. Тэмцээний нийлбэр дүнгээр сургагч ахлагч Б.Мөнгөн-Өлзий ахлагчтай мотобуудлагын батальоны хамт олон тэргүүн байр

ээзлж өргөмжлөл, шилжин явах цомын эзэд болсон бол ахлагч А.Жалбаа ахлагчтай гал унтраах алба, ахлах ахлагч Ч.Улаанхүү ахлагчтай авто, зэвсгийн албаны баг тамирчид удаах байруудад шалгарлаа. Цаашид энэхүү спортын цогцолбор тэмцээнийг жил бүр уламжлал болон зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

